

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны 9 дүгээр тэмдэглэлд:

"I.ХЭЛЭЛЦСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилсан "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Ерөнхийлөгчийн зарлигийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын санаачилсан "Засгийн газарт чиглэл өгөх тухай" Ерөнхийлөгчийн зарлигийн төслийг хэлэлцээд зарчмын хувьд дэмжиж, дараахь саналыг Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлахаар тогтов:

1. Зарлигийн төслийн 1.3 дахь дэд заалтын "телевиз, радиогоор нэвтрүүлэх..." гэснийг "...мэдээллийн хэрэгслээр явуулах..." гэж өөрчлөх;
2. Зарлигийн төслийн 1.2 дахь дэд заалтын "хөл хорио,", 1.3 дахь дэд заалтын "захыг хааж," гэснийг тус тус хасах." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР